

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2024/195/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Баян-Өлгий аймаг
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 99932710 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
Аудитор: Х.Манаргүл
Утас: 95429524 Цахим хаяг: manargulx@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

 БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 83129 Өлгий, Баян-Өлгий аймаг, Утас/Факс: (976) 7042-2954 E-mail: bayanulgi@audit.gov.mn	БУГАТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Ө.ХАРИЛБАЙ ТАНАА
2024.02.23 № 317	
танай _____	-ны № _____-т
Өөрчлөлтгүй дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p>	
Дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
Асуудлыг онцолсон хэсэг	
<p>Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлантай холбоотой онцлох үйл явдал гараагүй байна</p>	
Аудитын гол асуудал	
<p>Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.</p>	
Бусад асуудлын хэсэг	
<p>Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.</p>	
00402381	

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>14,153,500.00</u>	<u>5,542,181.00</u>
33	АВЛАГА	14,153,500.00	5,542,181.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	5,542,181.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	14,153,500.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>917,622,749.76</u>	<u>6,658,213,992.92</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	917,622,749.76	6,658,213,992.92
392	Биет хөрөнгө	877,674,749.76	6,616,980,253.92
39201	Барилга, байгууламж, орон сууц	955,181,499.93	955,181,499.93
39202	Хуримтлагдсан элэгдэл	(201,698,904.40)	(246,645,643.72)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	52,762,492.00	96,762,492.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(36,625,081.90)	(90,380,040.30)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	46,247,566.00	54,303,566.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(27,416,755.41)	(33,469,506.27)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	42,838,298.00	53,238,298.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(38,131,364.58)	(39,819,131.21)
39209	Зам, гүүрийн байгууламж	65,000,000.00	5,854,865,886.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(47,999,999.88)	(59,916,666.51)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	161,048,000.00	196,148,000.00
39212	Хуримтлагдсан элэгдэл	(93,808,000.00)	(123,565,500.00)
39217	Ном	277,000.00	277,000.00
393	Биет бус хөрөнгө	39,948,000.00	41,233,739.00
39301	Програм хангамж	1,936,400.00	3,359,639.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,611,400.00)	(1,748,900.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	39,623,000.00	39,623,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>931,776,249.76</u>	<u>6,663,756,173.92</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>12,932,321.00</u>	<u>3,865,703.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	12,932,321.00	3,865,703.00
413	Өглөг	12,932,321.00	3,865,703.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	12,253,956.00	3,865,703.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	678,365.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>918,843,928.76</u>	<u>6,659,890,470.92</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	918,843,928.76	6,659,890,470.92
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	326,816,008.00	326,816,008.00
51101	Өмч: - төрийн	326,816,008.00	326,816,008.00
512	Хуримтлагдсан үр дүн	417,698,143.91	6,158,744,686.07
51210	Өмнөх үеийн үр дүн	417,698,143.91	417,698,143.91
51220	Тайлант үеийн үр дүн	-	5,741,046,542.16
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	174,329,776.85	174,329,776.85
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>931,776,249.76</u>	<u>6,663,756,173.92</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
------------	----------	---------------------	-----------------------

1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	702,879,700.00	6,389,941,262.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	317,804,200.00	5,839,545,125.00
120	Нийтлэг татварын бус орлого	291,740,000.00	5,839,545,125.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	291,740,000.00	5,839,545,125.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	291,740,000.00	5,839,545,125.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	26,064,200.00	-
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	26,064,200.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	385,075,500.00	550,396,137.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,239,200.00	4,149,590.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,939,200.00	4,149,590.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	300,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	382,836,300.00	546,246,547.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	382,836,300.00	546,246,547.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	489,110,161.00	644,844,719.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	488,360,161.00	644,844,719.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	462,294,981.00	630,919,809.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	264,236,450.00	391,540,763.00
210101	Үндсэн цалин	193,337,434.00	276,109,381.64
210102	Нэмэгдэл	45,648,206.00	110,431,381.36
210104	Урамшуулал	-	5,000,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	25,250,810.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,238,119.00	51,047,300.00
210201	Тэтгэврийн даатгал	21,379,830.00	34,712,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,238,907.00	4,083,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	3,267,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	816,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,619,382.00	8,167,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,027,768.00	30,015,578.00
210301	Гэрэл, цахилгаан	708,168.00	1,415,778.00
210302	Түлш, халаалт	20,319,600.00	28,599,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,075,665.00	23,480,490.00
210401	Бичиг хэрэг	865,500.00	1,360,000.00
210402	Тээвэр, шатахуун	10,614,140.00	18,092,590.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,530,325.00	3,728,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	65,700.00	299,900.00
2105	Нормативт зардал	152,000.00	358,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	152,000.00	358,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	917,000.00	1,496,800.00

210601	Багаж, техник, хэрэгсэл	-	396,800.00
210604	Урсгал засвар	917,000.00	1,100,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,978,000.00	3,336,959.00
210702	Дотоод албан томилолт	1,978,000.00	3,336,959.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,914,020.00	2,827,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,899,520.00	1,482,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	362,200.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	60,000.00	180,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	178,900.00	399,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75,000.00	85,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	290,400.00	679,100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	48,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	118,755,959.00	126,816,719.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,709,579.00	12,229,338.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	458,700.00	230,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	97,587,680.00	100,203,881.84
210904	Найдваргүй авлагын алдагдал	-	14,153,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,065,180.00	13,924,910.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	26,064,200.00	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	26,064,200.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	13,814,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	13,100,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	714,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	980.00	110,410.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	980.00	110,410.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	750,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	750,000.00	-
223001	Бусад хөрөнгө	750,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>213,769,539.00</u>	<u>5,745,096,542.16</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	4,050,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	4,050,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(4,050,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>213,769,539.00</u>	<u>5,741,046,542.16</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>396,986,200.00</u>	<u>550,396,137.00</u>

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	26,064,200.00	-
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	26,064,200.00	-
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	26,064,200.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	370,922,000.00	550,396,137.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,239,200.00	4,149,590.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,939,200.00	4,149,590.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	300,000.00	
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	368,682,800.00	546,246,547.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	368,682,800.00	546,246,547.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>393,398,600.00</u>	<u>545,096,137.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	393,398,600.00	545,096,137.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	367,333,420.00	531,171,227.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	266,492,053.00	408,958,794.00
210101	Үндсэн цалин	177,918,802.00	293,527,412.64
210102	Нэмэгдэл	61,466,998.00	110,431,381.36
210104	Урамшуулал		5,000,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	27,106,253.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,019,900.00	51,047,300.00
210201	Тэтгэврийн даатгал	21,944,400.00	34,712,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,368,900.00	4,083,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,055,100.00	3,267,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	513,800.00	816,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,137,700.00	8,167,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,027,768.00	29,985,690.00
210301	Гэрэл, цахилгаан	708,168.00	1,125,000.00
210302	Түлш, халаалт	20,319,600.00	28,860,690.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,908,300.00	23,480,490.00
210401	Бичиг хэрэг	924,000.00	1,631,400.00
210402	Тээвэр, шатахуун	8,315,775.00	18,092,590.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,602,825.00	3,456,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	65,700.00	299,900.00
2105	Нормативт зардал	152,000.00	358,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	152,000.00	358,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	917,000.00	1,814,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		714,000.00
210604	Урсгал засвар	917,000.00	1,100,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,039,500.00	3,336,959.00
210702	Дотоод албан томилолт	2,039,500.00	3,336,959.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,488,620.00	2,539,888.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,454,720.00	1,195,388.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	362,200.00	
210803	Даатгалын үйлчилгээ	60,000.00	180,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	178,900.00	399,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75,000.00	85,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	296,800.00	679,100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	61,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,288,279.00	9,650,106.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,829,579.00	9,420,106.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	458,700.00	230,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,065,180.00	13,924,910.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	26,064,200.00	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	26,064,200.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	13,814,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		13,100,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		714,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	980.00	110,410.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	980.00	110,410.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>3,587,600.00</u>	<u>5,300,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,587,600.00	5,300,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,587,600.00	5,300,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,587,600.00	5,300,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,587,600.00	5,300,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(3,587,600.00)</u>	<u>(5,300,000.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	326,816,008.00	174,329,776.85	417,698,143.91	918,843,928.76
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	326,816,008.00	174,329,776.85	417,698,143.91	918,843,928.76
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	326,816,008.00	174,329,776.85	417,698,143.91	918,843,928.76
D08	Тайлант үеийн үр дүн			5,741,046,542.16	5,741,046,542.16
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	326,816,008.00	174,329,776.85	6,158,744,686.07	6,659,890,470.92

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	606,247,100.00	546,136,137.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	606,247,100.00	546,136,137.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	592,432,600.00	532,321,637.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	408,377,800.00	408,377,800.00
210101	Үндсэн цалин	294,410,100.00	292,946,418.64
210102	Нэмэгдэл	108,967,700.00	110,431,381.36
210104	Урамшуулал	5,000,000.00	5,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,047,300.00	51,047,300.00
210201	Тэтгэврийн даатгал	34,712,100.00	34,712,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,083,800.00	4,083,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,267,000.00	3,267,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	816,800.00	816,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,167,600.00	8,167,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,224,900.00	29,985,690.00
210301	Гэрэл, цахилгаан	1,125,000.00	1,125,000.00
210302	Түлш, халаалт	29,099,900.00	28,860,690.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,478,900.00	21,968,900.00
210401	Бичиг хэрэг	1,800,000.00	1,631,400.00
210402	Тээвэр, шатахуун	16,581,000.00	16,581,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,770,900.00	3,456,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	327,000.00	299,900.00
2105	Нормативт зардал	430,000.00	358,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	430,000.00	358,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,885,000.00	1,814,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	714,000.00	714,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	71,000.00	

210604	Урсгал засвар	1,100,000.00	1,100,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,037,000.00	2,986,959.00
210702	Дотоод албан томилолт	4,037,000.00	2,986,959.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	59,084,200.00	2,539,888.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	57,039,200.00	1,195,388.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	365,500.00	
210803	Даатгалын үйлчилгээ	180,600.00	180,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	399,800.00	399,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	85,000.00	85,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	838,000.00	679,100.00
210807	Газрын төлбөр	131,000.00	
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	45,100.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,867,500.00	13,243,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,153,500.00	12,716,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	714,000.00	527,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,814,500.00	13,814,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,814,500.00	13,814,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,100,500.00	13,100,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	714,000.00	714,000.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	606,247,100.00	546,136,137.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	606,247,100.00	546,136,137.00
132001	Орон нутгийн төсвөөс	606,247,100.00	546,136,137.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.00	25.00
620001	Удирдах ажилтан	8.00	8.00
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00
620003	Үйлчлэх ажилтан	9.00	9.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25.00	25.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9.00	9.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9.00	9.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7.00	7.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,239,200.00	4,149,590.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,239,200.00	4,149,590.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,239,200.00	4,149,590.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,439,200.00	1,511,590.00
210402	Тээвэр, шатахуун	1,409,200.00	1,511,590.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	300,000.00	350,000.00
210702	Дотоод албан томилолт	300,000.00	350,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00	2,288,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00	2,288,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,239,200.00	4,149,590.00

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,239,200.00	4,149,590.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,939,200.00	4,149,590.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	300,000.00	
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Бугат сумын Засаг даргын тамгын газар нь “Нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулан, төрийн бодлого шийдвэр, аймгийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй уялдуулан, орон нутгийн онцлог, давуу талд түшиглэсэн хөгжлийн хэтийн чиг хандлагыг оновчтой тодорхойлж, иргэдэд төрөөс үзүүлэх үйлчилгээг хууль тогтоомжийн дагуу хөнгөн шуурхай, ил тод явуулж, сумынхаа нийгэм, эдийн засгийн хөгжлийг хангахад оршино” гэсэн чиг үүрэгтэйгээ нийцсэн зорилго дэвшүүлж хэрэгжүүлж ажилласан байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр “Төр засгийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг оновчтой зохион байгуулж мэргэшсэн төрийн албан хаагчдаар төрийн албыг бүрдүүлэн иргэдэд төрийн үйлчилгээг ил тод шуурхай, тэгш хүртээмжтэй үзүүлэх” гэсэн зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Бугат сумын Засаг даргын тамгын газар нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Аймгийн Засаг даргын дэргэд Санхүүгийн хяналт аудитын албан ажилладаг. Тайлант онд ямар нэгэн шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 03 тоот тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж байна.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5731.9 сая төгрөгөөр буюу дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	14,153.5	5,542.2	(8,611.3)
Бараа материал	-	-	-
Үндсэн хөрөнгө	917,622.7	6,658,214.0	5,740,591.2
Нийт хөрөнгө	931,776.2	6,663,756.2	5,731,979.9
Өр төлбөр	12,932.3	3,865.7	(9,066.6)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	918,843.9	6,659,890.5	5,741,046.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	931,776.2	6,663,756.2	5,731,979.9

Дээрх хүснэгтээс харахад авлага, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансанд өөрчлөлт гарсан байна.

Авлагын данс 5.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч оны эхнээс 8.6 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага байна.

Бараа материалын данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй, төсвийн хөрөнгөөр нийт 15.5 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 15.5 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсан.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл оны эхнээс 5,740.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Төсвийн хөрөнгөөр 5.3 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 5789.9 сая төгрөгийн бетон гүүр, Засгийн газрын нөөц сангаас 7.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж, санхүүгийн программ, сумын ОНХС-гийн хөрөнгөөр 42.4 сая төгрөгийн тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгө, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2023 оны 205 дугаар тогтоолоор 50.0 сая төгрөгийн авто машиныг шилжүүлэн авч бүгд 5889.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, аймгийн ИТХ-ын

2023 оны 149 дугаар тогтоолоор 6.0 сая төгрөгийн авто машиныг аймгийн Цагдаагийн газарт шилжүүлсэн байна. Үндсэн хөрөнгөд нийт 100.2 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Өглөг дансны үлдэгдэл оны эхнээс 9.1 сая төгрөгөөр буурч 3.9 сая төгрөгийн өглөгтэй гарсан нь ажиллагсадтай холбоотой өглөг байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 5,741.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүн болон үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлттэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс 5741.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүн 5741.0 сая төгрөгө гарсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Бугат засаг даргын тамгын газар нь 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 475.5 сая, нийт зарлагыг 475.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 39.0 зардлыг сая төгрөгөөр бууруулж 436.5 сая төгрөгөөр баталсан байна.

Бугат засаг даргын тамгын газрын 2023 оны анх батлагдсан төсөв 436.5 сая төгрөг ба тодотгосон төсөв 606.2 сая төгрөг болж анх баталснаас 169.7 сая төгрөгөөр нэмж тодотгосон байна. Энэ нь Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор тайлант оны 7 дугаар сараас цалин нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэх 606.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр тусгасан ба гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 546.2 сая төгрөгийн санхүүжилт үйл ажиллагаа явуулсан байна.

Нийт төсвийн зарлагын 84.1 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, , 5.9 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 4.0 хувийг хангамж, бараа материалын зардал, 0.6 хувийг томилолтын зардал, 0.5 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, 2.4 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 2.5 хувийг бусад урсгал шилжүүлэг тус тус эзэлж байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 546.1 сая төгрөг буюу 90.1 хувьтай байгаа нь орон нутгийн төсвөөс 60.0 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосонтой холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	445,435.3	442,239.7	(3,195.6)	99.3
2	80102-Харуул, хамгаалалтын зардал	91,042.3	90,042.3	(1,000.0)	98.9
3	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	13,814.5	13,814.5	-	100.0

4	81701-Хөтөлбөр төслийн дотоод урсгал	55,955.0	150.0	(55,805.0)	0.3
	Дүн	606,247.1	546,246.5	(60,000.6)	90.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 0.3 сая, Засаг даргын тамгын газраас 1.0 сая, Статистикийн хэлтсээс 2.8 сая бүгд 4.1 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Бугат сумын Засаг даргын тамгын газарт 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Манаргүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 24 тоот дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 644.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 9.7 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзэв

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төсвийг хэмнэх талаар 29 арга хэмжээний хэрэгжилтийг шалгаж үзэхэд алдаа зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Бугат сумын Засаг даргын тамгын газар нь 2023 онд цалингийн зардлаас бусад орлогын 492.0 сая төгрөгийн 492.0 мөнгөн гүйлгээний мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас мэдээлэл, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн шийдвэрийг байршуулахаас мэдээллийг бүрэн байршуулсан байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилт 100 хувь байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн, хяналт дотоод аудитын албанаас шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйл гараагүй. Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалж тус байгууллагын үндсэн болон нэмэлт дансны санхүүжилтийн зарцуулалтын тооцоог бүрэн шалгах боломжгүй, зөвхөн санхүүгийн тайлан гаргалтыг шалгаж баталгаажууллаа.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 48734.3 мянган төгрөгийн алдаа¹ илэрч 48734.3 мянган төгрөгийн алдааг залруулсан.Үүнд:

Санхүүгийн байдлын тайланд богино хугацаат өр төлбөрийг 1056.0 мянган, Үр дүнгийн тайланд ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 43717.1 мянган, Мөнгөн гүйлгээний тайланд цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 580.9 мянган, Төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүжүүлэх эх үүсвэрийн гүйцэтгэлийг 110.4 мянган, зарлагын гүйцэтгэлийг 3379.5 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасныг залруулав.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын санхүүгийн тайлан гаргах заавар аргачлал, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 8487.6 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 3487.6 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 5000.0 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

Хууль хяналтын байгууллагад албан шаардлагаар шилжүүлсэн, хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн асуудал байхгүй.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар 3,487.6 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1.Сумын ЗДТГ-ын зарим албан хаагч нарт олгосон 3487.6 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг суутгаж аваагүй, санхүүгийн тайланд авлагаар тусгаж харуулаагүй орхигдуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.1 “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.2 “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Суутгаагүй урьдчилгааг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

Аудитаар 5.0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөгдлөө.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Цалингийн зардлаас 25 ажилтанд 5.0 сая төгрөгийн түлээ нүүрний хөнгөлөлт олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зарцуулах", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал"-тай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу зардлын эдийн засгийн ангиллыг мөрдөж, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар төлөвлөж, зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
ҮД, МГ, ТГТайлан	5	48733.0					5	48733.0				
Дүн	5	48733.0					5	48733.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хууль журам зөрчсөн	1	3487.6	1	3487.6								
Цалингийн зардлаас түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон	1	5000.0					1	5000.0				
Дүн	1	8487.6	1	3487.6			1	5000.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
							Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

